


Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ

2021 оны 12 дугаар сарын 31



Агуулга

Хараат бус аудиторын дүгнэлт	5
Орлогын дэлгэрэнгүй тайлан	9
Өмчийн өөрчлөлтийн тайлан	10
Мөнгөн гүйлгээний тайлан	11
Хараат бус аудиторын Үндэслэлтэй баталгаажуулалтын дүгнэлт	12
Үйл ажиллагааны зардлын төсөв гүйцэтгэлийн тайлан	15
Төсөл хөтөлбөрийн санхүүжилт, зарцуулалтын тайлан	17
Төсөл хөтөлбөрийн санхүүжилт, зарцуулалтын тайлан	18
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	19

Байгууллагын талаарх мэдээлэл

Байгууллагын нэр:	Говийн оюу хөгжлийг дэмжих сан ТББ	
Үүсгэн байгуулах шийдвэр:	Оюу толгой компани Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сумын хооронд 2015 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Хамтын ажиллагааны гэрээг байгуулж, уг гэрээний хэрэгжилтийг хангах зорилго бүхий "Говийн оюу хөгжлийг дэмжих сан" Төрийн бус байгууллагыг 2015 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр байгуулж улсын байгууллагад бүртгүүлсэн.	
Гэрчилгээ	2015 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Монгол улсын Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж 8186995 тоот регистр бүхий 1181001009 тоот улсын бүртгэлийн гэрчилгээг авсан.	
Удирдах зөвлөл	Дарга	Эндрью Уилсон
	Гишүүд	Б.Бадраа Р.Сэддорж Ж.Занабазар Мелисса Шаненганге Д. Амарбаясгалан Г. Сугар
	Итгэмжлэгдсэн зөвлөх	Б. Баяр
Удирдлагын баг:	Гүйцэтгэх захирал	С.Эрдэнэбат
	Санхүү хариуцсан мэргэжилтэн	Б.Батхуяг
	Төслийн менежер	С.Болдмаа
	Төсөл хөтөлбөрийн ажилтан	Б.Сугаржаргал
Хаяг:	Монгол улс, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3-р баг, Голомт бизнес төв, 4 давхар 404 тоот. Утас/Факс: 976-70533577 976-7053378 Цахим хаяг: www.goviinoyu.mn	
Регистрийн дугаар:	8186995	
Үйл ажиллагаа:	Өмнөговь аймгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх сан	
Ажиллагсадын тоо:	4	
Аудитор:	"Грант Торнтон Аудит" ХХК, Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, сургалт, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага	

Удирдлагын мэдэгдэл

Удирдлага нь санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, байгууллагын 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусвар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу] зохистой толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.
- Байгууллагын эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.
- Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, ирээдүйн үйл ажиллагаанд алдагдал хүлээж болзошгүй зүйлсийг байнга хянаж байх үүрэгтэй бөгөөд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага, болзошгүй зүйлсийн талаар тодруулсан.

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-ын УЗ-ийн дарга Эндрью Уилсон Гүйцэтгэх захирал С.Эрдэнэбат болон санхүү хариуцсан мэргэжилтэн Б.Батхуяг бид энэхүү тайлангийн 4-31 дүгээр хуудсанд үзүүлсэн байгууллагын санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх байгууллагын санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



УЗ-ийн дарга

Эндрью Уилсон

Огноо:



Санхүү хариуцсан мэргэжилтэн

Б. Батхуяг

Огноо: 2022.06.28

“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар,
ЮНЕСКО гудамж - 31,
Сүхбаатар дүүрэг,
1 хороо Улаанбаатар
14230, Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,
UNESCO street - 31,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230,
Mongolia
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Хараат бус аудиторын дүгнэлт

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-ын удирдлагад:

Дүгнэлт

Бид “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ (цаашид “Төрийн бус байгууллага” гэх)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлан,
- Уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ (цаашид “Төрийн бус байгууллага” гэх)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн баталсан Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус байгууллагаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

Аудитын аргачлалын хураангуй

Материаллаг байдал	<ul style="list-style-type: none">Санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 487,658.3 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо нийт орлогын 3%-аар тооцсон.Говийн оюу хөгжлийг дэмжих сан нь ашгийн бус буюу Төрийн бус байгууллага учир санхүүгийн тайлангийн нийт материаллагийг тодорхойлохдоо нийт орлогыг сонгосон. ТББ-ын үйл ажиллагаа нь хамтын гэрээний дагуу жил бүр 5 сая ам долларын санхүүжилтийг авч төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд үйл ажиллагаа тасалдсан, ашгийн түвшин хэлбэлзэлтэй зэрэг нөхцөл байдал үүсдэггүй тул нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгох нь зүйтэй гэж үзсэн.
--------------------	--

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Байгууллагын удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхыг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Байгууллагын дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.

- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн байгууллагын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Байгууллага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад чухал асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.



Огноо: 2022.06.22

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5	14,142,612	7,004,136
Богино хугацаа хөрөнгө оруулалт	6	2,034,107	1,559,256
Дансны болон бусад авлага		-	2
Эргэлтийн хөрөнгийн дүн		16,176,719	8,563,394
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	7	35,430	52,792
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		35,430	52,792
Нийт хөрөнгө		16,212,149	8,616,186
Өр төлбөр ба эздийн өмч			
Өр төлбөр			
Дансны болон бусад өглөг	8	9,968,968	2,599,954
Өр төлбөрийн нийт дүн		9,968,968	2,599,954
Цэвэр хөрөнгө			
Хуримтлагдсан ашиг	9	6,243,181	6,016,232
Цэвэр хөрөнгийн дүн		6,243,181	6,016,232
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		16,212,149	8,616,186

Хуудас 22-23 дугаар хуудсанд харуулсан тодруулгууд нь энэхүү санхүүгийн байдлын тайлангийн салшгүй нэг хэсэг болно

УЗ-ийн дарга
Эндрью Уилсон
Огноо:



Санхүү хариуцсан мэргэжилтэн
Б. Батхуяг
Огноо: 2022.06.28

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2021 он	2020 он
Үндсэн үйл ажиллагааны орлого			
Санхүүжилтийн орлого	10	16,255,279	14,629,916
Бусад орлого	11	206,555	503,711
		16,461,834	15,133,627
Үндсэн үйл ажиллагааны зардал			
Хандив тусламжийн зардал (байгууллага)	12	(866,500)	(322,596)
Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал	13	(197,437)	(138,650)
Төсөл хэрэгжүүлсний зардал	14	(14,721,673)	(11,639,467)
Ерөнхий удирдлагын зардал	15	(449,275)	(599,316)
		(16,234,885)	(12,700,029)
Үндсэн бус үйл ажиллагааны олз (гарз)			
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз		-	(166)
		-	(166)
Тайлант жилийн цэвэр үр дүн		226,949	2,433,432

Хуудас 24-28 дугаар хуудсанд харуулсан тодруулгууд нь энэхүү орлогын дэлгэрэнгүй тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Хуримтлагдсан үр дүн	Нийт
2020 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	3,582,800	3,582,800
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
Тайлант үеийн цэвэр үр дүн	2,433,432	2,433,432
2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	6,016,232	6,016,232
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
Тайлант үеийн цэвэр үр дүн	226,949	226,949
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	6,243,181	6,243,181

Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлого</i>		
Хандив тусламж	16,251,901	14,616,774
Бусад мөнгөн орлого	28,095	145,182
Мөнгөн орлогын дүн	16,279,996	14,761,956
<i>Мөнгөн зарлага</i>		
Ажиллагчдад төлсөн	166,970	183,750
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	41,601	21,650
Бараа материал худалдан авахад төлсөн	5,934	-
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэглүүрт төлсөн	8,277	11,030
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн төлбөр	8,589,247	12,934,934
Татварын байгууллагад төлсөн	19,424	42,280
Даатгалын төлбөрт төлсөн	130	97
Мөнгөн зарлагын дүн	8,831,583	13,193,741
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	7,448,413	1,568,215
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлого</i>		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
<i>Мөнгөн зарлага</i>		
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	403	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	325,071	270,299
Мөнгөн зарлагын дүн	325,474	270,299
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(325,474)	(270,299)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлого</i>		
Хүү болон урамшууллын орлого	15,537	327,432
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	15,537	327,432
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	7,138,476	1,625,348
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,004,136	5,378,788
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,142,612	7,004,136

Хараат бус аудиторын Үндэслэлтэй баталгаажуулалтын дүгнэлт

Далай тауэр 9 давхар,
ЮНЕСКО гудамж, Сүхбаатар
дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар 14230,
Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 fl, UNESCO
street, Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230, Mongolia
Т + 976 70 110744
+ 976 70 110799

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-ын удирдлагад:

Цар хүрээ

Бид “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-ын 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2022 оны 3 дугаар сарын 31-нээрх Төсөв, гүйцэтгэлийн тайлан (цаашид “тайлан” гэх) нь материаллаг зүйлсийн хувьд доор дурдсан нягтлах асуудал болон шалгуурт үндэслэн баталгаажуулалтын гэрээт ажлыг гүйцэтгэсэн.

Нягтлах асуудал

Бидний баталгаажуулалтын нөхцөл нь:

- Үйл ажиллагааны зардлын төсөв, гүйцэтгэлийн тайланд дүгнэлт өгөх
- Хандивлагч байгууллагын санхүүжилтийг холбогдох гэрээний нөхцөлийн дагуу зарцуулсан эсэхийг баталгаажуулах

Шалгуур

Баталгаажуулах гэрээт ажлыг гүйцэтгэхдээ доорх шалгуур, бусад асуудлыг үндэслэн дүгнэлтээ илэрхийлсэн. Үүнд:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-ын 2021 онд хандивлагч байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилт болон түүний зарцуулалт нь хандивлагч байгууллагатай хийсэн хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хийгдсэн эсэх,
- Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт санхүүжилтийн гэрээ хийгдсэн эсэх, санхүүжилт нь гэрээнд заагдсан хуваарийн дагуу үнэн зөв хийгдсэн байдал, хүлээн авсан санхүүжилтийг гэрээнд заагдсан гүйцэтгэлийн хугацаанд заагдсан ажилд зарцуулсан байх,
- Хандивлагч байгууллагаас ирүүлсэн санхүүжилтийг Санхүүгийн удирдамжийн дагуу хуваарилан Удирдах зөвлөлөөс баталсан төсвийн хүрээнд зарцуулсан байх,
- Санхүүгийн ажил гүйлгээ нь анхан шатны баримтын шаардлагыг хангаж, бүрдэл нь иж бүрэн байх.

Удирдлагын үүрэг хариуцлага

Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн удирдлага нь хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хандивлагч байгууллагын санхүүжилтийг зарцуулж, төсөв, гүйцэтгэлийн тайлангаа үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Бидний хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, үүнд ёс зүйн шаардлагын нийцлийн талаарх батлагдсан бодлого, горим, мэргэжлийн стандартууд болон холбогдох хуулийн шаардлагуудыг хангаж ажилласан.

Бидний үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага, нягтлах асуудал нь бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох шалгуурыг хангаж буй эсэхэд үндэслэлтэй баталгаа өгөх юм. Энэхүү гэрээт ажлыг Олон улсын Нягтлан бодогчдын холбооны Аудитын болон Баталгаажуулалтын олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан Баталгаажуулах гэрээт ажлын олон улсын стандарт 3000-ын дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн.

Баталгаажуулалтын түвшин

Үндэслэлтэй баталгаажуулалтын гэрээт ажил нь асуулга явуулах, шинжилгээ хийх, хяналтын тест гүйцэтгэх болон дүгнэлтийн үндэслэл болохуйц баталгаажуулалт олж авах зорилгоор хангалттай бусад нотолгоо цуглуулах горимуудаас бүрдэнэ. Гүйцэтгэх горим нь залилан эсвэл алдааны улмаас үүссэн мэдээллийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэл зэрэг шалгагч аудиторын мэргэжлийн шийдлээс хамаарна. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

Гүйцэтгэсэн ажлын хураангуй

Бид дараах горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд үүгээр хязгаарлагдаагүй. Үүнд:

- Төрийн бус байгууллагын бодлого, журамтай танилцах;
- Төрийн бус байгууллагын бодлого, журамд орсон өөрчлөлтүүдийг судлах;
- Зардлын зөвшөөрөл/ баталгаажуулалт болон дэмжих баримтын хүчин төгөлдөр байдлыг шалгах;
- Батлагдсан төсвийн дагуу зардлыг хуваарилсан эсэхийг шалгах;
- Данснууд, дэмжих баримт, санхүүгийн тайлан болон бусад тайлангийн арифметик тооцооллын үнэн зөв байдлыг шалгах;
- Төслийн үр ашигтай байдал болон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үйл явцыг баталгаажуулах;
- Батлагдсан төсөвтэй уялдуулан зардлыг баталгаажуулах;
- Зохистой бүртгэл, хөтлөлттэй байгаа эсэхийг шалгах;
- Бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын үйл явц нь Гэрээнд нийцсэн Худалдан авалтын дүрэм журмын дагуу зохистой эсэхийг шалгах;
- Өмнөх санхүүгийн шалгалтын тайлангийн үр дүнгээр илрүүлсэн асуудал, залруулга, зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг шалгах;
- Дотоод систем болон үйл явц нь зохистой бүрдсэн эсэхийг шалгаж, нотлох баримтаар баталгаажуулах.

Эдгээр горимыг асуулга явуулах, ажлын зураг авалт гүйцэтгэх, анхан шатны баримт шалгах, шинжилгээний горим гүйцэтгэх, тайлагнах бодлогын зохистой байдлыг үнэлэх, тулган баталгаажуулах зэрэг мэргэжлийн шийдэлд тулгуурлан гүйцэтгэсэн.

Баталгаажуулалтын хязгаарлалт

Гэрээт ажлын хүрээнд санхүүгийн тайлангийн энэхүү хараат бус үндэслэлтэй баталгаажуулалтын тайлан нь зөвхөн хандивлагч байгууллагад зориулан бэлтгэсэн бөгөөд өөр бусад зориллогүй болно.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр,

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ нь 2021 оны 12 дугаар сарын 31-ээр хандивлагч байгууллагын санхүүжилтээр дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээ, усны менежмент, орон нутгийн бизнес хөгжил, байгаль орчны менежмент, үндэсний түүх соёл аялал жуулчлалын 7 чиглэл, хандив тусламж болон тэтгэлэгт хөтөлбөрийн 2 чиглэлээр нийт 51 төслийг хэрэгжүүлж байгаа ба 2021 оноос өмнө гэрээ байгуулсан боловч санхүүжилт нь бүрэн олгогдоогүй байгаа төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн гүйцэтгэл нь 45 хувь, 2021 оны жилийн санхүүжилтийн гүйцэтгэл 40 хувь, нийт санхүүжилтийн гүйцэтгэл 43 хувьтай байна.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-ын 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс 2021 оны 12 дугаар сарын 31 хүртэлх үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 74 хувь, 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс 2022 оны 3 дугаар сарын 31 хүртэлх үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл нь 32 хувь байна.
- Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд нь санхүүжилтийн гэрээ байгуулсан ба санхүүжилт нь гэрээнд заагдсан хуваарийн дагуу хийгдэж, гүйцэтгэл нь гэрээнд заасан хугацаа болон журам, удирдамжийн дагуу зарцуулагдсан байна.
- Тайлант оны үйл ажиллагааны зардлын төсвийн зарцуулалтаар эд хөрөнгө худалдан авах, оффисын хэрэглээний зардлуудын хувьд үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл нь батлагдсан төсвийн дагуу зарцуулагдсан байна.
- Хандивлагч байгууллагаас ирүүлсэн санхүүжилтийг санхүүгийн удирдамжийн дагуу хуваарилан, Удирдах зөвлөлөөс баталсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- Санхүүгийн ажил гүйлгээ нь 11.1 тэрбум төгрөгийн и-баримтгүй (2020 онд шинэчлэгдсэн татварын багц хуулийн дагуу) зарцуулалтыг эс тооцвол анхан шатны баримтын шаардлагыг хангаж, бүрдэл нь иж бүрэн байна.



GRANT THORNTON
AUDIT LLC

GRANT THORNTON
АУДИТ УУХ

Б.ОСОРГАРАВ
УДИРДАХ ПАРТНЕР

УЛААНБААТАР ХСТ
10270051-10277542

Огноо: 2022.06.22

Үйл ажиллагааны зардлын ТӨСӨВ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон хугацааны хувьд:

		(мянган төгрөгөөр)			
Д/д	Зардлын ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт, /хэтрэлт/	Гүйцэтгэл хувь
1.1	Хөдөлмөрийн хөлс /Цалин, даатгал/	234,834	229,682	5,152	98%
1.2	ХДС-ийн оффисын зардал	52,926	42,034	10,892	79%
	<i>Захиргааны зардал /Интернэт, утас, шуудан/</i>	12,188	8,212	3,976	67%
	<i>Оффисын түрээс зардал</i>	16,988	16,988	-	100%
	<i>Хэрэгцээний зардал</i>	23,750	16,834	6,916	71%
1.3	Сурталчилгаа, хурлын зардал	153,540	94,650	58,890	62%
	Удирдах зөвлөл, Харилцаа хорооны хуралтай холбоотой зардал	48,640	2,555	46,085	5%
	Зарлал, сурталчилгаа, тараах материалын зардал	104,900	92,095	12,805	88%
1.4	Бусад	67,123	46,947	20,176	70%
	Хяналтын зардал	7,993	1,736	6,257	22%
	Сургалтын зардал	5,000	-	5,000	0%
	Итгэмжлэгдсэн зөвлөхийн зөвлөх үйлчилгээний зардал	8,000	8,000	-	100%
	Хөндлөнгийн аудитын зардал	30,000	28,000	2,000	93%
	Тээврийн зардал	16,130	9,211	6,919	57%
2.1	Нэмэлт зардал (Нэг удаагийн)	54,255	403	53,852	1%
	Болзошгүй зардал	53,555	-	53,555	0%
	Хөрөнгө худалдан авалт	700	403	297	58%
	Нийт төслийн зардал	562,678	413,716	148,962	74%

2022 оны 03 сарын 31-нээр дуусвар болсон хугацааны хувьд:

(мянган төгрөгөөр)

Д/д	Зардлын ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт, /хэтрэлт/	Гүйцэтгэл хувь
1.1	Хөдөлмөрийн хөлс /Цалин, даатгал/	234,834	54,766	3,943	23%
1.2	ХДС-ийн оффисын зардал	54,528	10,263	3,369	19%
	<i>Захирагааны зардал /Интөрнэт, утас, шуудан/</i>	14,040	6,016	(2,506)	43%
	<i>Оффисын түрээс зардал</i>	16,988	4,247	-	25%
	<i>Хэрэгцээний зардал</i>	23,500	-	5,875	0%
1.3	Сурталчилгаа, хурлын зардал	170,788	93,790	(51,093)	55%
	<i>Удирдах зөвлөл, Харилцаа хорооны хуралтай холбоотой зардал</i>	48,640	22,472	(10,312)	46%
	<i>Зарлал, сурталчилгаа, тараах материалын зардал</i>	122,148	71,317	(40,780)	58%
1.4	Бусад	78,527	3,073	16,559	4%
	<i>Хяналтын зардал</i>	7,992	-	1,998	0%
	<i>Сургалтын зардал</i>	5,000	89	1,161	2%
	<i>Итгэмжлэгдсэн зөвлөхийн зөвлөх үйлчилгээний зардал</i>	8,000	-	2,000	0%
	<i>Хөндлөнгийн аудитын зардал</i>	40,000	-	10,000	0%
	<i>Тээврийн зардал</i>	17,535	2,984	1,400	17%
2.1	Нэмэлт зардал (Нэг удаагийн)	24,000	18,630	(12,630)	78%
	<i>Хөрөнгө худалдан авалт</i>	24,000	18,630	(12,630)	78%
	Нийт төслийн зардал	562,677	180,520	(39,851)	32%

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ
 Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
 2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Төсөл хөтөлбөрийн санхүүжилт, зарцуулалтын тайлан

2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон хугацааны хувьд:

Төсөл хөтөлбөр	Батлагдсан санхүүжилт			Санхүүжилтийн гүйцэтгэл			Санхүүжилтийн үлдэгдэл			Санхүүжилтийн хувь
	Квот	Төсөл хөтөлбөр	Нийт дүн	Квот	Төсөл хөтөлбөр	Нийт дүн	Квот	Төсөл хөтөлбөр	Нийт дүн	
Дэд бүтэц, бүтээн байгуулалттай холбоотой төслүүд										
Нийгмийн дэд бүтэц				19,900	1,582,596	1,602,496				
Нийгмийн суурь үйлчилгээ				405,077	150,923	556,000				
Усны менежмент				41,871	-	41,871				
Орон нутгийн бизнес хөгжил	1,225,418	5,853,733	7,079,151	87,050	-	87,050	418,656	3,313,452	3,732,108	36%
Байгаль орчны менежмент				126,281	-	126,281				
Уламжлалт мал аж ахуй				91,110	-	91,110				
Үндэсний түүх соёл, аялал жуулчлал				35,473	-	35,473				
Дүн	1,225,418	5,853,733	7,079,151	806,762	1,733,519	2,540,281	418,656	8,959,037	3,732,108	36%
Хандив, тусламж, тэтгэлэгт хөтөлбөрүүд										
Хандив тусламж	-	866,500	866,500	-	866,500	866,500	-	-	-	100%
Ирээдүйн хойч үе сан	-	975,213	975,213	-	197,437	197,437	-	-	777,776	20%
Дүн	-	1,841,713	1,841,713	-	1,063,937	1,063,937	-	-	777,776	100%
Нийт дүн	1,225,418	7,695,446	8,920,864	806,762	2,797,456	3,604,218	418,656	8,959,037	4,509,884	40%

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ
 Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
 2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Төсөл хөтөлбөрийн санхүүжилт, зарцуулалтын тайлан

Он дамжин хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хувьд

Төсөл хөтөлбөр	Батлагдсан санхүүжилт			(Мянган төгрөгөөр)		
	Санхүүжилтийн үлдэгдэл	Нэмэлт санхүүжилт	Нийт дүн	Санхүүжилтийн гүйцэтгэл	Санхүүжилтийн үлдэгдэл	Гүйцэтгэлийн хувь
Дэд бүтэц, бүтээн байгуулалттай холбоотой төслүүд						
Нийгмийн дэд бүтэц				3,981,378		
Нийгмийн суурь үйлчилгээ				1,167,255		
Усны менежмент				-		
Орон нутгийн бизнес хөгжил	2,599,954	8,785,539	11,385,493	-	6,236,860	45%
Байгаль орчны менежмент				-		
Уламжлалт мал аж ахуй				-		
Үндэсний түүх соёл, аялал жуулчлал				-		
Нийт дүн	2,599,954	8,785,539	11,385,493	5,148,633	6,236,860	45%

Санхүүгийн тайлангийн тодруулгууд

1. Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ нь 2015 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Төрийн бус байгууллага хэлбэрээр Өмнөговь аймгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдан, Монгол улсын бүртгэлийн албанд бүртгүүлж, 8186995 тоот регистр бүхий 1181001009 тоот улсын бүртгэлийн гэрчилгээг авсан.

Үндсэн үйл ажиллагаа: Хамтын ажиллагааны гэрээнд заасны дагуу "Оюу толгой" ХХК-аас тус санд олгосон санхүүжилт болон аливаа санхүүжилтийг удирдан зохион байгуулах.

Дараах чиглэлээр төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, тэдгээрийг үр ашигтай, зүй зохистой удирдах зохион байгуулах зорилготойгоор үйл ажиллагаа эрхэлдэг. Үүнд:

- Усны менежмент
- Байгаль орчны менежмент (Нөхөн сэргээлт, биологийн төрөл зүйл болон экологийн тэнцвэрт байдал)
- Уламжлалт мал аж ахуй ба бэлчээрийн газрын менежмент
- Үндэсний түүх, соёл, аялал жуулчлал
- Нийгмийн суурь үйлчилгээ (Эрүүл мэнд, боловсрол, мэргэжлийн сургалт ба хөдөлмөр эрхлэлт)
- Орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, тэдгээрээс бараа, үйлчилгээ худалдан авах
- Дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төслүүд
- Түншлэгч сумдын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэгдсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, тэдгээрийг үр ашигтай, зүй зохистой удирдах, зохион байгуулах.

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- "Говийн оюу хөгжлийг дэмжих сан" нь 2016 оноос хойш "Говийн оюу – Бизнес боломж" нэртэй орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг бизнесийн бичил зээлийг Хаан банкаар дамжуулан олгож байна. 2016-2021 онд Өмнөговь аймгийн 51 бизнес эрхлэгч иргэдэд нийт 1.4 тэрбум төгрөгийн зээл олгосон,
- "Говийн оюу - Оюутны тэтгэлэг" хөтөлбөрийн хүрээнд 2021 онд магадлан итгэмжлэгдсэн дотоодын их, дээд сургуульд Өмнөговь аймагт дутагдалтай байгаа мэргэжлээр суралцаж байгаа 90 оюутанд тэтгэлэг олгосон,
- "Говийн Оюу хөгжлийг дэмжих сан" нь Хандив тусламжийн удирдамжийн дагуу Өмнөговь аймаг, тус аймгийн сумдад шаардлагатай тулгамдсан асуудал, журамд заасан хандивын төрлийн дагуу 2016-2021 онд нийт 2.1 тэрбум төгрөгийн Хандив тусламж олгосон,

2. Ерөнхий мэдээлэл, СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагааны таамаглал

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-д нийцүүлэн баталсан Сангийн сайдын заавар, журмын дугаар бэлтгэсэн болно.

Одоогоор СТОУС ашгийн бус байгууллагын НББ-ийн хандлага болон санхүүгийн тайлангийн толилуулгын талаар тодорхой зааварчилгаа агуулаагүй байна. Ашгийн бус секторын гүйлгээг НББ-д хэрхэн авч үзэх талаар СТОУС зааварчилгаа өгөөгүй бол нягтлан бодох бүртгэлийг бодлого нь

НББОУСЗ-ийн Санхүүгийн тайлагналын хүрээнд нарийвчлан тусгасан СТОУС-ын суурь үзэл баримтлалд суурилдаг.

Ковид-19-н санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийн ерөнхий үнэлгээ

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ-аас санхүүжилттэй Өмнөговь аймгийн Даланзадгад суманд баригдаж байгаа 1200 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэгийн гүйцэтгэлийн үйл явц удаашрахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. **Тухайлбал:**

- Өмнөговь аймагт барилгын ажиллах хүчин хомсдолтой байгаагаас шалтгаалан Улаанбаатар хотоос гэрээгээр ирж ажилладаг ажилчид Ковид-19 цар тахлын улмаас ирж ажиллаж чадахгүй мөн ажиллах хүчний зардал өссөн,
- Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас үүдэлтэйгээр хил гааль тодорхойгүй хугацаагаар хаагдсанаас барилгын материалын хомсдолд орсон,
- Барилгын материалын худалдан авалт хийхэд эрээний хилээр задгай тээвэр орж ирэхгүй зөвхөн чингэлэг тээврээр барилгын материалыг оруулж байгаа ба овор ихтэй материалууд орж ирж чадахгүй байгаа зэрэг асуудлууд нь цаг хугацаанд нь гүйцэтгэх, төсөвт зардал өсөхөд нөлөөлж байна.

Тасралтгүй үйл ажиллагаа

НББОУС 1-д заасны дагуу удирдлага нь тайлант хугацаанаас хойш багадаа 12 сарын ирээдүйн хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад эргэлзээ төрүүлэх асуудлууд байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай. Ийнхүү үнэлэхдээ одоогийн болон хүлээгдэж буй ашигт ажиллагаа, зээлийн эргэн төлөлтийн хуваарь, боломжит санхүүжилтийн эх үүсвэр болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадвар зэрэг өргөн хүрээний хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

Оюу толгой ХХК, Өмнөговь аймаг болон тус аймгийн ОТ төслийн түншлэгч сумд хооронд хамтын ажиллагаанд тулгуурласан 2015 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу жил бүр 5 сая ам долларын санхүүжилтээр санхүүждэг ба тус гэрээ нь ОТ төслийн ашиглалтын лиценз дуусах хугацаа буюу 2033 он хүртэл хүчинтэй бөгөөд цаашид сунгах боломжтой тул тус сангийн ирээдүйн хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад эргэлзээ төрүүлэхүйц биш гэж үзлээ.

3. Шинэ болон өөрчлөлт орсон стандартууд болон хэрэглээний тайлбарууд

3.1. 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн шинэ стандартууд

2021 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх мэдэгдлүүд байгаа бөгөөд тэдгээр нь байгууллагын санхүүгийн үр дүн болон байдалд томоохон нөлөө үзүүлэхээргүй байна.

3.2. Хүчин төгөлдөр болоогүй буюу хэрэглэж эхлээгүй стандартууд, стандартын нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд

Санхүүгийн тайланг баталсан өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөх хугацаа болоогүй НББОУСЗ-ийн өөрчлөлт оруулсан стандарт болон түүний тайлбарууд байгаа ба Байгууллага нь тэдгээр стандарт болон өөрчлөлтийг урьдчилан мөрдөж эхлээгүй байгаа юм.

Байгууллагын удирдлага тухайн өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр болох өдөр эсвэл түүний дараагаар мөрдөж эхлэхээр төлөвлөж байна. Тайлант онд дагаж мөрдөх шаардлагагүй тухайн өөрчлөлтүүдийг тодруулаагүй ба тэдгээр нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй.

4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

4.1. Бүртгэлийн суурь

Эдгээр санхүүгийн тайланг аккруэль сууриар бэлтгэсэн ба үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, хөрөнгө оруулалт болон тодорхой санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад зүйлсийг түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

4.2. Гадаад валют хөрвүүлэлт

Үйл ажиллагааны болон толилуулгын валют

Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг нь төслийн үндсэн үйл ажиллагаа болон ажил гүйлгээний эдийн засгийн бодит байдалд хамгийн тохиромжтой нөлөөлж байгаа учраас төгрөг нь уг төрийн бус байгууллагын үйл ажиллагааны валют юм.

Санхүүгийн тайлангуудын хэрэглэгчдэд хамгийн тохиромжтой гэж удирдлага үзэж байгаа учраас эдгээр санхүүгийн тайлангуудыг Монгол төгрөгөөр бүхэлтгэн толилуулна.

4.3. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх зорилгоор Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацааны хөрөнгө оруулалт зэргийг хамруулдаг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад зорилгоос илүү богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшдэг. Хэрэв мөнгөтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг бол байгууллага нь хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөөр ангилна.

4.4. Үндсэн хөрөнгө

Компьютер дагалдах хэрэглүүр болон бусад тоног төхөөрөмжийг зэрэг хөрөнгийг ашиглалтын байршилд авч ирэхэд гарсан зардлууд болон тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай гарсан зардлуудыг хамруулан худалдан авсан өртөг эсвэл үйлдвэрлэлийн өртгөөр анхлан бүртгэнэ. Санхүүгийн түрээсийн хөрөнгүүдийг барилга болон компьютер дагалдах хэрэглүүрийн адил бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа анхны өртөг болон хуримтлагдсан элэгдлийг данснаас хасна. Мөн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхэлнэ. Хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

Тээврийн хэрэгсэл	- 10 жил
Тавилга, эд хогшил	- 10 жил
Компьютер, тоног төхөөрөмж	- 2 жил
Бусад	- 10 жил

4.5. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгөнд [патент, гудвилл, франчайз, зохиогчийн эрх, лиценз, худалдааны тэмдэгт, программ хангамж, зохион байгуулалтын зардал] зэрэг хөрөнгүүд хамаарна.

Гаднаас худалдан авсан биет бус хөрөнгийг худалдан авалт хийсэн өдөр өртгөөр нь бүртгэнэ. Өртөг нь төлсөн мөнгөний дүн, өгсөн хөрөнгийн зах зээлийн үнэ, гарсан өр төлбөрт төлөх дүнгийн өнөөгийн үнэ цэнэ эсвэл хувьцаа гаргалтын хувьд хүлээн авсан санал бодлын зах зээлийн үнэ цэнээр хэмжигддэг.

Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн хувьд судалгаа хөгжүүлэлтийн зардлаас бусад өртөг зардлыг биет бус хөрөнгийн өртөгт капиталжуулдаг.

Биет бус хөрөнгийг хувьцаа болон өөр бусад мөнгөн бус хөрөнгөөр солилцох замаар олж бэлтгэж болно. Энэ тохиолдолд биет бус хөрөнгийн өртгийг шилжүүлэн өгсөн хөрөнгийн зах зээлийн үнэ эсвэл биет бус хөрөнгийн зах зээлийн үнэ хоёрын аль тодорхой байгаа үнээр үнэлнэ.

Дотооддоо хөгжүүлсэн программ хангамж

Мэдээлэл технологийн, харилцаа холбооны системийн зорилгоор шинээр хөгжүүлж буй программ хангамжийн судалгааны зардлыг гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

Хөгжүүлэлтийн үе шатанд гарсан зардлыг дараах шаардлагыг хангаж байгаа тохиолдолд биет бус хөрөнгөнд хуримтлуулан бүртгэнэ. Үүнд:

- Хөгжүүлэлтийн зардлыг бодитоор хэмжиж болох
- Төслийн техникийн болон арилжааны үр дүн амжилттай болох нь тодорхой
- Групп нь тухайн төслийг хэрэгжүүлж дуусгахад шаардлагатай хангалттай нөөцтэй
- Тухайн программыг ашиглах эсвэл борлуулах боломжтой
- Тухайн программаас ирээдүйн эдийн засгийн өгөөж ирэх нь тодорхой

Дээрх капиталжуулалтын шаардлагыг хангаагүй зардлууд нь зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө.

Холбогдох зардлуудад программ хөгжүүлэхтэй холбоотой гарсан ажилчдын зардал, зээлийн өртөг болон нэмэгдэл зардлууд нь хөгжүүлэлтэд хамаарах хэмжээгээр хуваарилагдана.

4.6. Орлого хүлээн зөвшөөрөлт

Орлогыг ТББ-ын зөвшөөрсөн санхүүжүүлэгч байгууллагын санхүүжилт, банкны хүүгийн орлого мөн бусад үндсэн бус үйл ажиллагааны орлогыг хүлээж авсан эсвэл авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Мөн орлогыг нягтлан бодох бүртгэлийн аккруал сууриар хүлээн зөвшөөрнө.

Орлого хүлээн зөвшөөрөхдөө байгууллага нь дараах таван алхмыг мөрддөг. Үүнд:

1. Үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээг тодорхойлох
2. Гэрээний үүрэг хариуцлагын биелэлтийг тодорхойлох
3. Арилжааны үнийг тодорхойлох
4. Арилжааны үнийг гэрээний гүйцэтгэх үүргүүдэд хуваарилах
5. Аж ахуйн нэгж гүйцэтгэх үүргээ биелүүлсэн үедээ орлогыг хүлээн зөвшөөрөх

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ нь Оюу толгой болон Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сумтай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор хуанлийн жил бүр 5 сая долларын санхүүжилт хүлээн авдаг. Тус санхүүжилт нь буцах нөхцөлгүй тул байгууллага санхүүжилтийг хүлээн авсан тухай бүр орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх зарчмыг баримтална. Харин үнэ төлбөргүй, хандиваар хүлээн авсан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой орлогыг тухайн буцалтгүй тусламжийг хүлээн авсан эсвэл буцалтгүй тусламжид холбогдох нөхцөлийг биелүүлсэн үед уг бүтээгдэхүүн үйлчилгээний бодит үнэ цэнтэй тэнцэх дүнгээр хүлээн зөвшөөрөх ба уг нөхцөл хангагдах хүртэл хойшлуулж бүртгэнэ.

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ-ын нийт орлогыг үйл ажиллагааны (хандив тусламжийн орлого) болон үйл ажиллагааны бус орлого гэж ангилна.

4.7. Зардал

Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон хандивын зардлыг гэрээний дагуу буцаан татах нөхцөлгүйгээр санхүүжигчид олгох нь тодорхой болсон буюу санхүүжигч төсөл, хөтөлбөр, хандив тусламжийн гэрээний дагуу биелүүлэх нөхцөлийг бүрэн хангасан үед зардлыг хүлээн зөвшөөрнө.

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ нь Удирдах зөвлөлийн 2018 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн №10 тоот тогтоолын дагуу тайлант жилийн санхүүжилтийг Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралын заалтуудтай уялдсан байдлаар хуваарилалтын зарчмыг баримтлан

зарцуулах үүрэг хүлээнэ. Энэ тогтоолоор баталсан чиглэл болон хувь хэмжээ нь тодорхой хугацааны дараа өөрчлөгдөж болох ба өөрчлөлт нь бодлогын салшгүй нэг хэсэг байна.

Хамтын ажиллагааны гэрээний дагуу төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр байгуулсан санхүүжилтийн гэрээг байгуулж, нягтлан бодох бүртгэлд төсөл хөтөлбөрийн зардлыг аккрузал сууриар хүлээн зөвшөөрөн, гүйцэтгэгч байгууллагад өгөх өглөг үүсгэн бүртгэдэг байна. Өөрөөр хэлбэл төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон хандивын зардлыг гэрээний дагуу буцаан татах нөхцөлгүйгээр санхүүжигчид олгох нь тодорхой болсон буюу санхүүжигч төсөл, хөтөлбөр, хандив тусламжийг гэрээний дагуу биелүүлэх нөхцөлийг бүрэн хангасан үед зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

4.8. Ажилчдын богино хугацааны тэтгэмж

Богино хугацааны ажилчдын тэтгэмж

Ажилчдын богино хугацааны тэтгэмжид хамаарах амралтын мөнгө зэрэг тэтгэмжийг тэтгэмж болон бусад үүргийн дансанд дискаунтлаагүй дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Ажилчдад олгох богино хугацааны тэтгэмж ажилчид холбогдох үйлчилгээ үзүүлсэн жилийн тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор олгох тэтгэмж бөгөөд дараахийг багтаана. Үүнд:

- цалин урамшуулал;
- ээлжийн амралтын мөнгө, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;
- Нийгмийн даатгалын шимтгэл болон бусад нийгмийн төлбөрүүд
- Үр дүнгийн урамшуулал

Урамшуулал

Байгууллага нь зөвхөн өнгөрсөн үйл явдлын үр дүнд мөн үүрэг хариуцлагын найдвартай тооцоолол хийх боломжтой тохиолдолд тийм төлбөр хийх өнөөгийн хууль ёсны болон үүсмэл үүрэг хүлээсэн бол урамшууллын төлбөрийн хүлээгдсэн өртгийг хүлээн зөвшөөрнө.

Өнөөгийн үүрэг хариуцлага зөвхөн тухайн аж ахуйн нэгжид төлбөр хийхээс өөр бодитой хувилбар байхгүй тохиолдолд л оршино.

4.9. Засгийн газрын буцалтгүй тусламж

Засгийн газрын буцалтгүй тусламжийг уг тусламжийн нөхцөлийг байгууллага биелүүлэх ба тусламжийг хүлээж авна гэсэн үндэслэлтэй баталгаа бий болох хүртэл хүлээн зөвшөөрөхгүй.

Бусад засгийн газрын буцалтгүй тусламжийг системтэй сууриар холбоотой зардлыг харгалзан нөхөх байдлаар уг зардлыг хэрэгжих тайлангийн үеүдэд орлогоор хүлээн зөвшөөрнө.

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ нь тайлант хугацаанд 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсан Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн дагуу 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс 2021 оны 06 дугаар сарын 30-ныг хүртэл нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт чөлөөлөлтөнд хамрагдсан байна.

4.10. Нийгмийн даатгалын шимтгэл

Төлөөлөгчийн газар нь Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу тус байгууллагын ажилтнуудад олгосон цалин болон түүнтэй адилтгах орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцож, төсөвт төлж, тайлагнах үүрэгтэй. Төлөөлөгчийн газрын ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэл нь эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ.

4.11. Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тухайн оны татвар ногдох орлогод төлөх татварын өглөг болон өмнөх онуудтай холбоотой татварын өглөгийн залруулга юм.

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйл, 23.1 дугаар зүйл болон ААНОАТ-ын тухай хуулийн 4.1.1 дүгээр зүйл, 26 дугаар зүйлээр тодорхойлж, заасны дагуу татвар төлөгч болох бөгөөд байгууллага нь ААНОАТ-ын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу чөлөөлөгдөх орлогод хамаарах, ашгийн төлөө бус байгууллага тул Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдөнө.

Төлөөлөгчийн газрын ажилтнуудад олгосон цалин болон түүнтэй адилтгах орлого, бусад хувь хүнд олгосон аливаа орлогод Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу татварыг 10%-иар ногдуулан суутгаж, төсөвт шилжүүлэх үүрэгтэй.

5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь дараахаас бүрдэнэ:

Мянган төгрөгөөр	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Касс дахь мөнгө	1,168	654
Банкин дахь үлдэгдэл		
- Төсөл хөтөлбөрийн данс (5585638858)	11,965,811	5,294,344
- Үйл ажиллагааны данс (5585644465)	173,699	147,445
- Хандив тусламжийн данс (5585672708)	10,563	16,115
- Оюутны тэтгэлэгт хөтөлбөрийн данс (5585673654)	315,076	194,330
- Хөнгөлөлттэй зээлийн данс (5585675200)	1,544,539	1,219,468
- Тусгай данс 5608101254	131,756	131,780
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	14,142,612	7,004,136

Тус сан нь тайлант хугацааны санхүүжилтээс 7,550,934.0 мянган төгрөгийг төсөл хөтөлбөр санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

6. Богино хугацаат хөрөнгө оруулалт

Мянган төгрөгөөр	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Эхний үлдэгдэл	1,559,256	1,130,316
Нэмэх нь:		
Хадгаламжийн санхүүжилт	325,071	270,299
Хадгаламжийн хүүгийн орлого	166,422	158,641
Хасах нь:		
Хүүгийн зардал	16,642	-
Богино хугацаат хөрөнгө оруулалтын дүн	2,034,107	1,559,256

Богино хугацаат хөрөнгө оруулалт нь хамтын ажиллагааны гэрээний дагуу "Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ-ийн үйл ажиллагааныхаа хүрээнд төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх санхүүжилтийн удирдамж"-ийн 4.1-т байгуулсан "Ирээдүй хойч үеийн төлөө" зориулалт бүхий Хаан Банк дахь 5585675222 тоот төгрөгийн хадгаламжийн данс нь юм.

"Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх санхүүжилтийн удирдамж"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-д Хойч үеийн төлөө сан, мөн Удирдах зөвлөлийн 2016 оны 9 сарын 19-ний өдрийн 05 тоот тогтоолоор баталсан "Өмнөговийн ирээдүй хойч үеийн төлөө сан"-ийн журмыг тус тус үндэслэн Өмнөговь аймгийн Хаан банкны салбарт жилийн 16 хувь (сарын 1.3 хувь) 10 жилийн хугацаатай байхаар тохиролцон жил бүр 100,000 ам.доллартой тэнцэх хэмжээний мөнгийг байршуулдаг ба тайлант хугацаанд 325,071.0 мянган төгрөгийг хадгаламжийн дансанд байршуулж 166,422.0 мянган төгрөгийн хүүгийн орлого олсон байна.

7. Үндсэн хөрөнгө

Мянган төгрөгөөр	Тавилга, эд хогшил	Компьютер, дагалдах хэрэгсэл	Тээврийн хэрэгсэл	Бусад хөрөнгө	Нийт
Өртөг					
2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	13,073	32,730	18,000	11,494	75,297
Нэмэгдсэн	403	-	-	-	403
Хасагдсан	-	10,767	-	-	10,767
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	13,476	21,963	18,000	11,494	64,933
Үлдэгдэл өртөг					
2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	3,568	9,506	5,402	4,029	22,505
Байгуулсан элэгдэл	1,330	13,487	1,799	1,149	17,765
Данснаас хассан	-	10,767	-	-	10,767
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	4,898	12,226	7,201	5,178	29,503
Үлдэгдэл өртөг					
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	9,505	23,224	12,598	7,465	52,792
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	8,578	9,737	10,799	6,316	35,430

Тайлант хугацаанд гүйцэтгэх захирлын 08 дугаар тоот тушаалаар элэгдэж дууссан нийт 10,767 мянган төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг компьютер, дагалдах хэрэгслийг акталж данс бүртгэлээс хассан байна.

8. Дансны болон бусад өглөг

Мянган төгрөгөөр	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Хүннүгийн говь ХХК	5,616,263	1,052,182
Аглут ХХК	417,515	847,995
GIZ	131,782	131,782
Ханбогд-Арвижих ХХК	439,581	-
Гранд холдинг ХХК	516,134	-
Эвтцахирал ХХК	2,110,302	-
Гранд лайн прожект ХХК	128,079	-
Бусад өглөг	609,312	567,995
Дансны болон бусад өглөгийн дүн	9,968,968	2,599,954

Хамтын ажиллагааны гэрээний дагуу төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр байгуулсан санхүүжилтийн гэрээг байгуулж, санхүүгийн бүртгэлд төсөл хөтөлбөрийн зардлыг аккруэл сууриар хүлээн зөвшөөрөн байгууллагад өгөх өглөг үүсгэн бүртгэсэн байна.

9. Хуримтлагдсан ашиг

Үйл ажиллагаа эхэлсэн үеэс нэмэгдсэн капитал. Энэ нь тухайн тайлангийн хугацаанд олсон цэвэр ашгийн хэмжээгээр нэмэгдэнэ.

Мянган төгрөгөөр	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Эхний үлдэгдэл	6,016,232	3,582,800
Нэмэх нь:		

Тайлант оны хуримтлагдсан ашиг	226,949	2,433,432
Эцсийн үлдэгдэл	6,243,181	6,016,232

10. Санхүүжилтийн орлого

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
"ОТ" ХХК Хандив тусламжийн орлого	16,255,279	14,629,916
Санхүүжилтийн орлогын дүн	16,255,279	14,629,916

"Оюу Толгой" ХХК нь 2015 оны 4 сарын 22-ны өдөр Өмнөговь аймаг болон Ханбогд сумтай "Хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулсан, гэрээний 8.1 дэх заалтын дагуу гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор "Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан" ТББ-ыг үүсгэн байгуулж, гэрээний 8.3-т заасны дагуу "Оюу Толгой" ХХК-иас жил бүр 5,000,000 ам.доллартой тэнцэх хэмжээний төгрөгийн санхүүжилтийг олгох гэрээтэй. Гэрээний дагуу тайлант хугацаанд 16,255,279 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүртгэсэн байна.

11. Бусад орлого

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
Хүүний орлого	181,960	503,711
Бусад орлого	24,595	-
Бусад орлогын дүн	206,555	503,711

Богино хугацаат хөрөнгө оруулалтын Хаан банк дахь 5585675222 тоот төгрөгийн хадгаламжийн (жилийн 16 хувь) дансанд 166,423 мянган төгрөгийн хүүний орлого, Хаан банк дахь төгрөгийн харилцах данснуудын үлдэгдэлд тооцсон 15,557 мянган төгрөгийн хүүний орлогыг бүртгэсэн байна. Мөн GIZ болон "Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ хооронд байгуулсан 3 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээний дагуу ЖДҮ-чадавжуулах хамтарсан хөтөлбөр дуусаж санхүүжилтийн үлдэгдэл төлбөр болох 24,595 мянган төгрөгийн бусад орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

12. Хандив тусламжийн зардал

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
Ханбогд суманд овоо тахиx хандив	2,500	
Даланзадгад сумын малчдад өвс тэжээл авах хандив	414,000	
Даланзадгад суманд үүссэн үерийн хохирлыг барагдуулах хандив	200,000	
Ковидын хандив	250,000	322,596
Хандив тусламжийн зардлын дүн	866,500	322,596

13. Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
Оюутны тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	-	138,650
Оюутны сургалтын төлбөр	56,388	-
Тэтгэлэгт хөтөлбөр удирдах байгууллагын зардал	7,900	-
Оюутны тэтгэлэгт хөтөлбөр намрын төлбөр	133,149	-
Хандив тусламжийн зардлын дүн	197,437	138,650

14. Төсөл хэрэгжүүлсний зардал

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
Нийгмийн дэд бүтэц	11,922,534	8,183,605
Нийгмийн суурь үйлчилгээ	1,811,599	2,449,147
Усны менежмент	569,419	43,824
Орон нутгийн бизнес хөгжил	112,500	766,416
Байгаль орчны менежмент	154,750	36,835
Уламжлалт мал аж ахуй	107,300	-
Үндэсний түүх соёл, аялал жуулчлал	43,571	159,640
Төсөл хэрэгжүүлсний зардлын дүн	14,721,673	11,639,467

14.1 Нийгмийн дэд бүтэц

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дүн
ГОХДС/2021-01	ДЗ 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга	Ханбогд-Арвижих ХХК	2,197,903
ГОХДС/2021-02	Гашуунсухайт боомтын хяналтын камераар тоноглогдсон харуулын байр	Хилийн 0131-р анги	188,880
ГОХДС/2021-03	Өмнөговь аймагт шинээр баригдаж буй музейн үзмэрийн баяжилт	Археологийн хүрээлэн	149,000
ГОХДС/2021-05	Музейн гадна тохижилт	Андгай ХХК	148,935
ГОХДС/2021-06	ДЗ ерөнхий төлөвлөгөө	ММ архитектур ХХК	250,000
ГОХДС/2021-09	Музейн палеонтологийн үзмэрийн баяжилт	Палеонтологийн хүрээлэн	200,000
ГОХДС/2021-10	Цогт-Овоо 15 ортой эмнэлгийн барилга	Эвт цахирал ХХК	3,014,717
ГОХДС/2021-11	ДЗ сумын үйлдвэрийн бүсийн дэд бүтцийн зураг төсөв	Гранд лайн прожект ХХК	128,079
ГОХДС/2021-12	Дата төвийн барилгын зураг төсөв	Хязгааргүй шулуун ХХК	39,900
ГОХДС/2020-12-01	ДЗ 1200 хүүхдийн цэцэрлэгийн барилга	Хүннүгийн говь ХХК	5,585,220
КСМО/2021-01	Эмнэлгийн эрсдэлгүй орчин	Алтан муфть ХХК	19,900
Нийт дүн			11,922,534

14.2 Нийгмийн суурь үйлчилгээ

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дүн
	Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн хамтарсан хөтөлбөр	НҮБ Хүн амын сан	1,167,255
ГОХДС/2021-04	Буянт хотхон зуслангийн цайны газрын тоног төхөөрөмж нийлүүлэх	Ихэр сайхан уул ХХК	158,866
КСБД/2021-03	Журмын хашаа	Б.Ганболд	10,000
КСБД/2021-04	Явуулын үйлчилгээ	Ж.Мөнх-Эрдэнэ	16,000
КСЦО/2021-03	Эмнэлгийн тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл	Бурят омбол ХХК	6,849
КСЦО/2021-01	Бид өнөөдрийн уншигч-маргаашийн манлайлагч	Бөх дүүрэн ХХК	9,864
КСХБ/2021-06	Нэг цэг	Д.Нарансүрэн	7,500
КСХБ/2021-04	Эрдмийн оргил	М.Мажигсүрэн	15,380
КСХБ/2021-03	Сагсан бөмбөг	Ханбогд хот тохижилт ОНӨААТҮГ	7,080
КСХБ/2021-02	Гадна тохижилт	Н.Өлзийбаяр	21,026
КССВ/2021-01	Эмийн сан	Нөрөөтговь ХХК	15,600
КССВ/2021-02	Ахмадын сургаал алт	Сэврэн хөгжил ТББ	7,490
КССВ/2021-03	Түргэн тусламж-2	Сангийн далай энерги ХХК	63,000
КСМЛ/2021-08	Ахмадын өргөөний гадна тохижилт	Н.Пунцагболд	25,000

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ
 Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
 2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дүн
КСМЛ/2021-05	Хөгжмийн боловсрол хүүхдийн ирээдүй	Д.Бүрэнжаргал	8,500
КСМЛ/2021-06	Эрүүл эх хүүхэд-эрүүл Манлай	Э.Балжирмаа	7,000
КСМЛ/2021-01	Цэвэр Манлай	А.Гантөмөр	40,674
КСМЛ/2021-02	Эмнэлгийн хог хаягдлын менежмент	Д.Уламбаяр	13,000
КСМЛ/2021-03	Үдийн цайны гал тогооны тоног төхөөрөмж	Б.Лхамсүрэн	25,000
КСДЗ/2021-02	Дотуур байр бидний гэр	Зэмүү говь ХХК	14,500
КСДЗ/2021-03	Сургалтын таатай орчин	Софт бюлдинг эффект ХХК	15,000
КСБО/2021-03	Цэвэр агаар-Эрүүл мэнд	Баянтансаг эрдэнэ ХХК	40,000
КСБО/2021-04	Эмнэлгийн түргэн тусламж	Шанх чандмань ХХК	20,000
КСМО/2021-02	Стандартан нийцсэн соёлтой үйлчилгээ	Монголын менежментүүдийн холбоо ТББ	5,000
КСМО/2021-03	Итгэдийн оролцоо нутгийн хөгжил	Энгүүн очир констракшн ХХК	48,790
КСМО/2021-04	Эрсдэлийн сангийн зарцуулалт - Цогт-Овоо сум	Цогт-Овоо сумын ЗДТГ	4,275
КСМО/2021-05	Эрсдэлийн сангийн зарцуулалт - Мандал-Овоо сум	Д.Түвшинзул	4,230
КСМО/2021-06	Эрсдэлийн сангийн зарцуулалт - Манлай	Манлай сумын ЗДТГ	7,124
КСМО/2021-07	Эрсдэлийн сангийн зарцуулалт - Даланзадгад	Зэмүү говь ХХК	18,996
КСМО/2021-08	Эрсдэлийн сангийн зарцуулалт - Баян-Овоо	Ивээлтгүн ХХК	7,000
КСМО/2021-09	Эрсдэлийн сангийн зарцуулалт - Булган	Булган сумын ЗДТГ	1,600
Нийт дүн			1,811,599

14.3 Усны менежмент

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дүн
ГОХДС/2021-07	Бэлчээр усжуулалтын 2-р аян багц-1	Гранд холдинг ХХК	256,119
ГОХДС/2021-08	Бэлчээр усжуулалтын 2-р аян багц-2	Гранд холдинг ХХК	260,015
КСБГ/2021-01	Булган сумын ус түгээх байранд цахим систем	Коск заг ОНӨААТҮГ	18,285
КСБД/2021-01	Далай булаг	Б.Баяржаргал	10,000
КСБД/2021-02	Хот айл	Д.Оюунбилэг	15,000
КСХБ/2021-08	Гар аргаар худаг гаргах	Т.Базарсад	10,000
Нийт дүн			569,419

14.4 Орон нутгийн бизнес хөгжил

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дүн
КСХБ/2021-05	Ханбогд брэнд багц	М.Норовсүрэн	10,000
КСНМ/021-01	Баянбулаг тоног төхөөрөмж	Н.Тунгалаг	83,000
КСДЗ/2021-04	Номадик говь ХХК	Афор ХХК	19,500
Нийт дүн			112,500

14.5 Байгаль орчны менежмент

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дүн
КСХБ/2021-09	Багт мод тарих	Б.Шинэбаяр	9,750
КСХБ/2021-01	Цэмцгэр Ханбогд	Ханбогд хот тохижилт	70,000
КСБО/2021-02	Цэвэр сум	Эко Баян-Овоо хот тохижилт ААТҮГ	55,000
КСБО/2021-01	Говийн төгөл	Дархан төгөлдөр говь ХХК	20,000
Нийт дүн			154,750

14.6 Уламжлалт мал аж ахуй

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дүн
КСЦО/2021-04	Мал угаалгын дүк автомашин	Цогт-Овоо нутаг ХХК	44,500
КСЦО/2021-02	Зөвөрийн хяналтын сууц	Ю.Болдбаатар	19,500
КСХБ/2021-07	Малын им тамга	М.Сүглэгмаа	25,800
КСМЛ/2021-04	Малын им, тамга	Б.Пэрэнлэймаа	3,000
КСДЗ/2021-05	Жишиг мал эмнэлэг	Дүүрэн шаргал элс ХХК	14,500
Нийт дүн			107,300

14.7 Үндэсний түүх соёл, аялал жуучлал

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дүн
КСБГ/2021-02	Музейн тохижуулалт	Б.Мөнх-Ундрэм	19,571
КСМЛ/2021-07	Түүх, өв соёл	Д.Отгонбат	13,000
КСХБ/2021-10	Баян дэлгэрэх	Д.Хишигбат	11,000
Нийт дүн			43,571

Тус сан нь тайлант хугацаанд батлагдсан төсөл хөтөлбөрийн хүрээнд нийт 51 байгууллагатай гэрээ байгуулж гэрээний дагуу дээрх байгууллагууд нь үйл ажиллагаагаа эхлээд байгаа ба 40 хувийн гүйцэтгэлтэй байна.

15. Ерөнхий удирдлагын зардал

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
Зар сурталчилгааны зардал	92,095	218,814
Цалин хөлс, шагнал	203,346	202,520
Татварын зардал	18,196	50,371
Нийгмийн даатгалын шимтгэл	26,337	25,406
Зөвлөх үйлчилгээний зардал	36,000	20,100
Түрээсийн зардал	16,988	16,988
Бичиг хэргийн зардал	6,661	16,488
Элэгдлийн зардал	17,765	14,213
Хангамжийн материалын зардал	-	7,370
Шатахууны зардал	5,272	6,023
Шуудан, холбооны зардал	8,212	5,358
Сэлбэг, багаж хэрэгслийн зардал	3,639	5,341
Удирдах зөвлөл, ХХ хуралтай холбоотой зардал	2,555	4,555
Албан томилолтын зардал	-	1,414
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	1,195	1,115

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
Банкны шимтгэлийн зардал	913	1,014
Сонин сэтгүүл захиалгын зардал	-	804
Засвар үйлчилгээний зардал	306	440
Хяналтын зардал	1,735	290
Сургалтын зардал	45	281
АТБӨЯТХ -ийн татварын зардал	140	141
Даатгалын зардал	130	97
Бусад зардал	7,745	173
Ерөнхий удирдлагын зардлын дүн	449,275	599,316

16. Холбоотой талын ажил гүйлгээ

Тайлант хугацаанд тус байгууллага нь дараах ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн бөгөөд тайлант хугацааны эцсээр дараах үлдэгдэлтэй байна.

Холбоотой талуудын нэр	Харьяалал	Хамаарал	Ажил гүйлгээ	2021
"Оюу Толгой" ХХК	Монгол улсын хуулийн этгээд	Үүсгэн байгуулагч	Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт	16,255,279
Өмнөговь аймаг, Ханбогд сум бусад түншлэгч сум	Монгол улсын хуулийн этгээд	Хамтын ажиллагааны гэрээний дагуу удирдан зохион байгуулагчид	Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хандив, дэмжлэг	-
Тим Экерсли	Австрали улсын иргэн	Удирдах зөвлөлийн дарга	Хурал, уулзалт	-
Х.Сугир	Монгол улсын иргэн	Удирдах зөвлөлийн гишүүн	Хурал, уулзалт	-
Н.Наранбаатар	Монгол улсын иргэн	Удирдах зөвлөлийн гишүүн	Хурал, уулзалт	-
Б.Эрдэнэ-Очир	Монгол улсын иргэн	Удирдах зөвлөлийн гишүүн	Хурал, уулзалт	-
Деррик Хансен	Австрали улсын иргэн	Удирдах зөвлөлийн гишүүн	Хурал, уулзалт	-
Д.Амарбаясгалан	Монгол улсын иргэн	Удирдах зөвлөлийн гишүүн	Хурал, уулзалт	-
Г.Сугар	Монгол улсын иргэн	Удирдах зөвлөлийн гишүүн	Хурал, уулзалт	-
С.Эрдэнэбат	Монгол улсын иргэн	Гүйцэтгэх захирал	Цалин хөлс	72,031

17. Болзошгүй өр төлбөр

Тайлант хугацаанд байгууллагын эсрэг хуулийн зарга маргаантай холбоотой болзошгүй өр төлбөр байхгүй байна.

18. Тайлагналын үеийн дараах үйл явдал

Тайлагналын өдөр буюу 2021 оны 12 дугаар сарын 31 болон энэхүү тайланг баталгаажуулсан өдөр хоорондын хугацаанд ямар нэгэн залруулагдах эсвэл үл залруулагдах томоохон гүйлгээ гараагүй болно.

19. Орчуулга

Эдгээр санхүүгийн тайланг Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд Монгол болон Англи хувилбар хооронд зөрүү гарвал, Монгол хувилбарыг дагах болно.

20. Санхүүгийн тайлангийн баталгаажуулалт

2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон санхүүгийн тайланг 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр удирдлага батлав.

УЗ-ийн дарга

Эндрью Уилсон

Огноо:



Санхүү хариуцсан мэргэжилтэн

Б. Батхуяг

Огноо: